



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	3
2.1. Оршил.....	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	6
2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....	6
2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	7
2.8.3.1 Үндсэн хөрөнгө болон тушаал шийдвэрийн талаар	7
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Шилэн дансны мэдээлэл	8
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
3.1 Зардалтай холбоотой асуудал.....	9
3.2 Зардалтай холбоотой асуудал.....	9
3.3 Харьяа Төсвийн шууд захирагчдад илэрсэн алдаа зөрчилтэй холбоотой асуудал	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Хавсралт	17
5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17
5.2 Албан шаардлага.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА А.АРИУНЗАЯА
ТАНАА

2019.04.25 № 840
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



4. Аудитын тайлан

2.1. Оршил

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч тус хорооны дарга А.Ариунзаяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардал, харьяа байгууллагад илэрсэн алдаа зөрчлийн талаар Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 05-наас 2019 оны 4 дүгээр сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцан гүйцэтгэв.

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 01/297 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.



Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим сорилыг гүйцэтгэн шат шатны чанарын хяналтыг хийлгэн, холбогдох нотлох зүйлсийг баталгаажуулан баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ҮСХ-ны даргын багцын талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

ҮСХ 2018 онд статистикийн хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдааг хангаж, хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, статистикийн үйл ажиллагаанд технологийн дэвшлийг хөгжүүлэх хүрээнд 6 зорилго, 25 зорилт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 онд бүрэн хэрэгжүүлсэн байна.

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын удирдлага төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Статистикийн тухай хууль
- Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.



ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна. Мөн Засгийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн “Э-Тайлан” програмыг хэрэглэдэг байна.

Харин үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Хяналт шинжилгээ, мониторингийн хэлтэс нь 2018 онд 17 ажил төлөвлөж бүрэн хийж гүйцэтгэсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг ҮСХ-ны 2018 оны эхний хагас жилийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувь буюу 101.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг ҮСХ-ны 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 11,421.8 сая төгрөгийн 2 хувь буюу 228.4 сая төгрөгөөр тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.



2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 23 байгууллага аудитад хамрагдсан байна.

Хүснэгт 1 Санхүүгийн тайланд аудит хийсэн хэлбэр:

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	18	2	3	-
2	Төвийн ерөнхийлөн захирагч	1			
	Дүн	19	2	3	-

Эх сурвалж: Санхүүгийн аудитын 2018 оны аудитын тайлан.

Дээрх хүснэгтээс үзвэл аудитаар 18 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” 3 санхүүгийн тайланд “Итгэл үзүүлсэн”, 2 санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 182.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 14.4 хувь буюу 26.2 сая төгрөгийн залруулга, 2.1 хувь буюу 3.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 60.5 хувь буюу 110.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 23 хувь буюу 42.0 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2 (Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр, сая төгрөгөөр)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	23	80.7	3	3.8	5	46.4	15	30.5
2	ТЕЗ /түүвэр/	3	75.4	-	-	1	63.9	2	11.5
	Дүн	26	156.1	3	3.8	6	110.3	17	42.0

Эх сурвалж: Санхүүгийн аудитын 2018 оны аудитын тайлан.

2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Үндэсний статистикийн хорооны аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 30.5 сая төгрөгийн 15 зөвлөмж, 46.4 сая төгрөгийн 5 албан шаардлага, 3.8 сая төгрөгийн 3 акт тогтоосон байна.



2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцон шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.3.1 Үндсэн хөрөнгө болон тушаал шийдвэрийн талаар

Аудитаар хэсэгчилсэн тооллого хийхэд 1.5 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг IPAD биетээр байхгүй, ажиллагсдын үр дүнгийн урамшуулалд 62.4 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн Тамгын газрын даргын 2018 оны А/53, А/54 дүгээр тушаалын эрх зүйн үндэслэл алдаатай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.3-т "эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн бодолт, цагийн бүртгэл, дахин үнэлгээний талаар гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд ҮСХ-ны төсвийн зардалд 9,487.7 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 8,571.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зардлын нийт гүйцэтгэл 8,571.8 сая төгрөг буюу 90.3 хувьтай байна. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 40.6 хувь буюу 3,482.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжинд 49.6 хувь буюу 4,254.7 сая төгрөг, бараа материалд 4.9 хувь буюу 417.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансанд 3,765.0 сая төгрөгийн орлого, зардал бүртгэгдэж тайлагнасан байна. Үүнд:

Орлого:

- НҮБ-ын Хүн амын сангаас 595.4 сая төгрөг
- НҮБ-ын Хүүхдийн сангаас 510.4 сая төгрөг
- Өртгийн зэрэгцүүлэлтийн судалгааны 83.5 сая төгрөг



- Ажиллах хүчний судалгааны 96.5 сая төгрөг
- Байгаль орчин, эдийн засгийн данс байгуулах судалгааны 70.7 сая төгрөг
- Орон нутгийн статистикийн газар хэлтсүүд орон нутгийн засаг даргын нөөц хөрөнгөнөөс 117.4 сая төгрөг
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2,144.0 сая төгрөг
- Урьд оны татаас санхүүжилтийн авлагаас 81,2 сая төгрөг

Нэмэлт төсвийн дансанд нийт 3,765.0 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс 3,669.6 сая төгрөгийг судалгаанд зарцуулж 95.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс 90.5 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

ҮСХ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт оруулбал зохих 259 мэдээллээс хугацаандаа оруулсан 189 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 68 мэдээлэл, хүлээгдэж буй 2 мэдээлэл байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж 100 хувийн биелэлттэй байна. Зөвлөмжийн биелэлтийн талаар Үндэсний статистикийн хорооны 2018 оны 03/792 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



Ж. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБООС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ҮСХ-ны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Холбогдох агрегат засвар, гүйлтийн нормыг тодорхойлоогүй, техник хяналтын акт үйлдээгүйгээр автомашины засварт нийт 9.7 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тогтоолын хавсралт 9, 11-т заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан, залилан үүсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тогтоолын хавсралт 9, 11-т заасныг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Шинээр 1.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан боловч шууд зардлаар бүртгэсэн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, хөрөнгө шамшигдах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг мөрдөж ажиллах.



3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Харьяа Төсвийн шууд захирагчдад илэрсэн алдаа зөрчилтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Нийт 106.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 3.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 46.4 сая төгрөгийн 5 албан шаардлага, 30.5 сая төгрөгийн 15 зөвлөмж, 26.2 сая төгрөгийн 9 залруулга хийсэн байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль эрх зүй зөрчигдөх маргаан гарах.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хяналт шинжилгээ, мониторингийн хэлтэст дотоод хяналтыг сайжруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



→. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	401,414.9	303,357.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	67,232.2	892.8
АВЛАГА	83,959.7	91,285.2
УРЬДЧИЛГАА	6,369.9	0.0
БАРАА МАТЕРИАЛ	243,853.0	211,179.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,611,307.6	1,449,904.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,611,307.6	1,449,904.2
Биет хөрөнгө	1,333,465.3	1,289,052.5
Биет бус хөрөнгө	277,842.3	160,851.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,012,722.6	1,753,262.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,848.0	559.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,848.0	559.2
Өглөг	3,848.0	559.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,008,874.6	1,752,702.8
Засгийн газрын хувь оролцоо	2,008,874.6	1,752,702.8
Хуримтлагдсан үр дүн	2,008,874.6	1,746,858.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.0	5,844.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,012,722.6	1,753,262.0



→.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,300,454.4	11,197,535.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	909,328.1	489,723.8
Нийтлэг татварын бус орлого	229,295.4	489,723.8
Тусламжийн орлого	680,032.6	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,391,126.4	10,707,811.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,570,419.1	11,422,441.0
УРСГАЛ ЗАРДАЛ	11,570,419.1	11,422,441.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,924,871.1	10,643,125.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,616,363.5	3,718,477.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	386,269.1	437,121.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,000.0	0.0
Хангамж, бараа материалын зардал	487,497.2	491,925.9
Нормативт зардал	182.0	444.0
Эд хогшил, урсгал засварын зардал	162,614.0	40,671.6
Томилолт, зочны зардал	854,340.5	341,065.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,250,446.0	4,870,410.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1,166,158.7	743,009.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	645,548.1	779,315.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-269,964.7	-224,905.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	52,015.8	724.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-321,980.5	-225,630.4

➔.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,241,913.8	10,762,540.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	696,614.5	8,174.4
Нийтлэг татварын бус орлого	16,581.9	8,174.4
Тусламжийн орлого	680,032.6	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,545,299.4	10,754,365.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,221,467.0	10,819,510.1
УРСГАЛ ЗАРДАЛ	11,221,467.0	10,819,510.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,423,365.4	9,949,682.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,702,162.9	3,721,708.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	375,322.0	436,973.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,000.0	0.0
Хангамж, бараа материалын зардал	454,272.7	463,591.6
Нормативт зардал	182.0	444.0
Эд хогшил, урсгал засварын зардал	314,275.1	56,054.2
Томилолт, зочны зардал	730,901.2	341,121.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,194,464.8	4,753,537.8
Бараа үйлчилгээний бусад зардал	650,784.8	176,251.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	798,101.5	869,827.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,446.8	-56,969.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	213,336.7	9,369.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	213,336.7	9,369.6
Дотоод эх үүсвэрээр	213,336.7	9,369.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-213,336.7	-9,369.6
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-7,405.2	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	7,405.2	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-200,295.0	-66,339.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	267,527.3	67,232.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,232.2	892.8



4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,327,501.0	0.0	2,327,501.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,354.1	0.0	3,354.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,330,855.1	0.0	2,330,855.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-321,980.5	0.0	-321,980.5
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,008,874.6	0.0	2,008,874.6
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,008,874.6	0.0	2,008,874.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-36,385.6	0.0	-36,385.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,972,489.0	0.0	1,972,489.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	5,844.2	0.0	5,844.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-225,630.4	0.0	-225,630.4
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,752,702.8	0.0	1,752,702.8



→.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,487,662.7	8,571,812.4	915,850.3	90.3
УРСГАЛ ЗАРДАЛ	9,487,662.7	8,571,812.4	915,850.3	90.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,358,227.8	8,442,502.0	915,725.8	90.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,491,119.9	3,482,571.7	8,548.2	99.8
Үндсэн цалин	2,409,614.0	2,417,700.3	-8,086.3	100.3
Нэмэгдэл	610,522.2	603,276.9	7,245.3	98.8
Унаа хоолны хөнгөлөлт	211,041.6	208,014.2	3,027.4	98.6
Гэрээт ажлын хөлс	259,942.1	253,580.2	6,361.9	97.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	418,935.2	417,895.8	1,039.4	99.8
Хангамж, бараа материалын зардал	148,802.6	144,189.3	4,613.3	96.9
Бичиг хэрэг	27,311.2	30,623.5	-3,312.3	112.1
Тээвэр, шатахуун	45,855.4	44,694.3	1,161.1	97.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,497.3	43,069.9	3,427.4	92.6
Ном, хэвлэл	16,526.2	13,710.3	2,815.9	83.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,612.5	12,091.4	521.1	95.9
Эд хогшил, урсгал засварын зардал	43,535.8	39,254.3	4,281.6	90.2
Урсгал засвар	43,535.8	39,254.3	4,281.6	90.2
Томилолт, зочны зардал	39,002.9	32,839.7	6,163.2	84.2
Дотоод албан томилолт	39,002.9	32,839.7	6,163.2	84.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,099,467.5	4,254,683.4	844,784.1	83.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,771,802.4	3,983,703.4	788,099.0	83.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,407.0	2,103.4	303.6	87.4
Даатгалын үйлчилгээ	19,800.6	19,725.5	75.1	99.6
Тээврийн хэрэгслийн татвар	2,569.5	1,988.3	581.2	77.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	653.1	466.9	186.2	71.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	53,500.0	53,436.0	64.0	99.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	248,734.9	193,259.7	55,475.2	77.7
Бараа үйлчилгээний бусад зардал	117,363.9	71,067.8	46,296.1	60.6
Бараа үйлчилгээний бусад зардал	28,065.9	23,840.1	4,225.8	84.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	89,298.0	47,227.7	42,070.3	52.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,434.9	129,310.5	124.4	99.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	18,635.2	18,635.2	0.0	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	18,635.2	18,635.2	0.0	100.0
Бусад урсгал шилжүүлэг	110,799.7	110,675.3	124.4	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	74,329.7	74,329.7	0.0	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,470.0	36,345.6	124.4	99.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,487,662.7	8,528,304.3	959,358.4	89.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,463,279.4	8,521,002.2	942,277.2	90.0
Улсын төсвөөс санхүүжих	9,463,279.4	8,521,002.2	942,277.2	90.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	7,302.1	-7,302.1	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,302.1	-7,302.1	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	43,528.6	-43,528.6	



Үндэсний статистикийн хорооны даргын багцын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20.5	-20.5	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	672	672	0.00	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	32	32	0.00	100.0
Төсвийн байгууллага	32	32	0.00	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	320	320	0.00	100.0
Удирдах ажилтан	34	34	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	239	239	0.00	100.0
Гэрээт ажилтан	47	47	0.00	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	320	320	0.00	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	266	266	0.00	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.00	100.0
Гэрээт ажилтан	47	47	0.00	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0.00	100.0



Ж. Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код:	САГ-2019/17/СТА-ТЕЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:	Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага			сая төгрөгөөр			
№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
А	1	2	3	4	5	9	10
1	Зардал	1	Холбогдох агрегат засвар, гүйлтийн нормыг тодорхойлоогүй, техник хяналтын акт үйлдээгүйгээр автомашины засварт нийт 9.7 сая төгрөг зарцуулсан байна.	9.7	Зөвлөмж	Санхүүгийн хэлтсийн дарга	Д.Батсүх
2	Зардал	2	Шинээр 1.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан боловч шууд зардлаар бүртгэсэн байна.	1.8	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Б.Оюундэлгэр
3	ТЕЗ-ийн нэгтгэл /	1	Харьяа ТШЗ нарт нийт 106.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс 3.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 46.4 сая төгрөгийн 5 албан шаардлага, 30.5 сая төгрөгийн 15 зөвлөмж, 26.2 сая төгрөгийн 9 залруулга хийсэн байна.	106.9	Зөвлөмж	1. ҮСХ-ны дарга 2. Ерөнхий нягтлан бодогч	1. А.Ариунзаяа 2. Б.Оюундэлгэр
4	Үндсэн хөрөнгө болон тушаал шийдвэр	1	Аудитаар хэсэгчилсэн тооллого хийхэд 1.5 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг IPAD биетээр байхгүй, ажиллагсдын үр дүнгийн урамшуулалд 62.4 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн Тамгын газрын даргын 2018 оны А/53, А/54 дүгээр тушаалын эрх зүйн үндэслэл алдаатай байна.	63.9	Албан шаардлага	Тамгын газрын дарга	Ч.Цэвэгдорж



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 04 дугаар сарын 22

№ 05/2019

Улаанбаатар хот

САН-2019/17/СТЭ-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасан цаглабарт хугацаанд хийсэн Үндэсний статистикийн хорооны даргын багцын 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аудитаар хэсэгчилсэн тооллого хийхэд 1 ширхэг 1.5 сая төгрөгийн үнэтэй IPAD биетээр байхгүй байна.
- Тамгын газрын даргын 2018 оны А/53, А/54 дүгээр тушаалын үндэслэл алдаатай үр дүнгийн урамшуулалд 62.4 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.3-т "Эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитын хэсэгчилсэн тооллогоор дутсан хөрөнгийн талаар холбогдох арга хэмжээ авч эргэж хариу мэдэгдэх, тушаал шийдвэрийн үндэслэлийг үнэн зөв бэлтгэж байх.
2. Биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа, Санхүүгийн хэлтсийн дарга Д.Батсүх нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР *[Signature]* Д.ЦЭГМИДДОРЖ
УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА А.АРИУНЗАЯА
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.БАТСҮХ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гээж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.